



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 19 өдөр

Дугаар A/17

Жаргалтхаан

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. XVII жарны Хөхөгчин хэмээх модон могой жилийн сар шинийн баярыг тохиолдуулан улс, аймаг, сумын сайн малчин, сумын алдарт уяачаар шалгарсан хавсралтад заагдсан малчдад шагнал гардуулсугай.

2. Малчдын шагналд зориулж 3,500,000 (гурван сая таван зуун мянган) төгрөгийг зарцуулсугай.

3. Дээрх зардалд шаардагдах 3,500,000 (гурван сая таван зуун мянган) төгрөгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга С.Мөнхдэлгэр, Нягтлан бодогч Э.Загдхүү нарт зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Н.Отгонбаяр)-д даалгасугай.

ДАРГА



С.ГАНБАТ